ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2025/151/НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mnP Ховд хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 99013699 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Балжинням<br>Утас:99435309 Цахим хаяг: baljinnyamd@gmail.com |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025. 02. 24 № 2/78

танай ____________-ны №____________-т

ХОВД СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Д.АХГҮЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- *Шууд худалдан авалтаар тендерээр нийлүүлж байгаа эм, эмийн хэрэгслээс илүү үнээр 402.7 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, эм, эмийн хэрэгслийн үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан 17,525.7 мянган төгрөг,*
- *Насжилт өндөртэй 2,107,6 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгслийн үлдэгдэл ихтэй, 13,224.1 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл орлого аваагүй,*
- *Шатахууны зардалд 8,168,7 мянган төгрөг анхан шатны баримт хангалтгүй, замын хуудсаар баталгаажуулаагүй, дотоод хяналт болон бүртгэлээр тавих хяналт сул;*
- *Өмнөх оны зөвлөмжөөр өгөгдсөн зөвлөмж хэрэгжээгүй, хөрөнгийг ангилан зөв бүртгээгүй 31,119.0 мянган төгрөгийн зөрчил,*
- *Агуулахын бүртгэл хөтлөөгүй, хүнсний тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, агуулах эмх цэгцгүй, эд хөрөнгийн карт хөтлөөгүй, нярвын*

*тайлан хангалтгүй, хөрөнгийг ангилан бүртгээгүй 16,590. мянган төгрөгийн зөрчлүүд илэрсэн*

**Асуудлыг онцолсон хэсэг**

Ховд сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд улс, орон нутгийн төсвөөр 135,222.1 мянган төгрөгийн өртөгтэй эмнэлгийн шинэ машин, 68,146.9 сая төгрөгийн өртөгтэй тавилга, тоног төхөөрөмжөөр хангагдаж иргэдэд хүрэх эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжтэй болох нөхцөл бүрдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад улмэж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг 8 зорилт 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89,5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан сумын Засаг даргаар баталгаажуулаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **79,537,206.77** | **229,578,130.03** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 30,601,798.97 | 1,499,229.84 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 30,601,798.97 | 1,499,229.84 |
| **3121** | **Төгрөг** | 30,601,798.97 | 1,499,229.84 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 30,601,798.97 | 1,499,229.84 |
| **33** | **АВЛАГА** | 20,170,490.24 | 167,188,446.29 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 128,229.24 | 128,230.65 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 19,743,913.00 | 166,761,867.64 |
| **335** | **Бусад авлага** | 298,348.00 | 298,348.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 298,348.00 | 298,348.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 28,764,917.56 | 60,890,453.90 |
| **351** | **Түүхий эд материал** | 11,534,278.64 | 19,547,502.00 |
| 35130 | Эм боох материал | 11,534,278.64 | 19,547,502.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 17,230,638.92 | 41,342,951.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 430,300.00 | 1,718,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,999,185.02 | 14,027,300.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,542,699.90 | 638,797.90 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,258,454.00 | 24,958,454.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **390,819,338.72** | **543,099,737.92** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 390,819,338.72 | 543,099,737.92 |
| **392** | **Биет хөрөнгө** | 378,502,728.38 | 530,840,252.62 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 298,000,440.62 | 298,000,440.62 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (48,217,059.60) | (59,527,425.24) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 65,550,220.00 | 203,672,220.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (31,736,670.55) | (54,453,137.77) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 186,238,290.62 | 264,460,290.62 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (94,530,803.81) | (125,186,371.95) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,231,040.00 | 23,131,040.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18,032,728.90) | (19,256,803.66) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 12,316,610.34 | 12,259,485.30 |
| 39301 | Програм хангамж | 982,000.00 | 982,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (763,989.66) | (821,114.70) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12,098,600.00 | 12,098,600.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **470,356,545.49** | **772,677,867.95** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **9,854,355.15** | **53,628,483.52** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 9,854,355.15 | 53,628,483.52 |
| **413** | **Өглөг** | 9,854,355.15 | 53,628,483.52 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 3,893,361.42 | 35,942,641.14 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 5,960,993.73 | 17,685,842.38 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **460,502,190.34** | **719,049,384.43** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 460,502,190.34 | 719,049,384.43 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 160,773,037.00 | 160,773,037.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 160,773,037.00 | 160,773,037.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 177,410,271.90 | 435,957,465.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 177,410,271.90 | 177,410,271.90 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 258,547,194.09 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 122,318,881.44 | 122,318,881.44 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **470,356,545.49** | **772,677,867.95** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **671,580,518.04** | **1,152,196,806.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **79,105,237.41** | **229,587,915.35** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 79,105,237.41 | 229,587,915.35 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 79,105,237.41 | 229,587,915.35 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 79,105,237.41 | 229,587,915.35 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **592,475,280.63** | **922,608,891.75** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 20,535,913.00 | 837,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 792,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,743,913.00 | 837,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 37,786,400.00 | 40,200,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 37,786,400.00 | 40,200,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 534,152,967.63 | 881,570,991.75 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 75,297.00 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 534,077,670.63 | 881,570,991.75 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **614,356,803.21** | **893,649,612.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **614,356,803.21** | **893,649,612.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 614,156,803.21 | 893,649,612.66 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 371,881,220.00 | 611,673,770.90 |
| 210101 | Үндсэн цалин | 246,992,007.00 | 356,354,312.69 |
| 210102 | Нэмэгдэл | 86,649,359.00 | 181,313,165.83 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,799,000.00 | 30,777,000.00 |
| 210104 | Урамшуулал | 33,440,854.00 | 43,229,292.38 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 48,692,542.42 | 67,823,439.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,875,865.50 | 46,119,938.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,704,169.23 | 5,425,875.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,963,335.38 | 2,712,937.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 740,833.85 | 2,712,937.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,408,338.46 | 10,851,750.24 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,785,213.73 | 34,888,857.81 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,744,733.73 | 2,030,146.16 |
| 210302 | Түлш, халаалт | 29,040,480.00 | 32,858,711.65 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,683,873.98 | 31,117,355.02 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,101,255.00 | 3,574,020.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,345,073.00 | 20,878,150.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,551,000.00 | 1,835,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,679,045.98 | 4,830,185.02 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 7,500.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 66,338,185.27 | 68,844,988.99 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 56,017,735.27 | 59,789,487.34 |
| 210502 | Хоол, хүнс | 10,320,450.00 | 9,055,502.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 5,855,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 4,450,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,405,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,226,000.00 | 1,440,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,226,000.00 | 1,440,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,565,660.00 | 964,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,242,000.00 | 414,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 143,660.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 180,000.00 | 100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 53,984,107.81 | 71,042,200.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,176,100.00 | 5,078,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 47,808,007.81 | 65,963,600.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 200,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **57,223,714.83** | **258,547,194.09** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 160,773,037.00 | 122,318,881.44 | 124,146,557.07 | 407,238,475.51 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (3,960,000.00) | (3,960,000.00) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **160,773,037.00** | **122,318,881.44** | **120,186,557.07** | 403,278,475.51 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 57,223,714.83 | 57,223,714.83 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **160,773,037.00** | **122,318,881.44** | **177,410,271.90** | 460,502,190.34 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **160,773,037.00** | **122,318,881.44** | **177,410,271.90** | 460,502,190.34 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **160,773,037.00** | **122,318,881.44** | **177,410,271.90** | 460,502,190.34 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 258,547,194.09 | 258,547,194.09 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **160,773,037.00** | **122,318,881.44** | **435,957,465.99** | 719,049,384.43 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **572,731,367.63** | **774,753,137.11** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **572,731,367.63** | **774,753,137.11** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 792,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 792,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 37,786,400.00 | 40,200,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 37,786,400.00 | 40,200,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 534,152,967.63 | 734,553,037.11 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 75,297.00 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 534,077,670.63 | 734,553,037.11 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **563,160,699.73** | **803,855,706.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **563,160,699.73** | **803,855,706.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **562,960,699.73** | **802,295,252.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 356,891,695.73 | 577,505,438.35 |
| 210101 | Үндсэн цалин | 218,118,116.80 | 306,002,525.71 |
| 210102 | Нэмэгдэл | 82,456,559.45 | 181,982,316.29 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,806,044.06 | 30,790,261.22 |
| 210104 | Урамшуулал | 51,510,975.42 | 58,730,335.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 58,367,400.00 | 73,239,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,955,400.00 | 52,042,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,310,000.00 | 5,299,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,760,800.00 | 2,649,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 939,700.00 | 2,649,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,401,500.00 | 10,598,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,786,400.00 | 36,984,646.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,744,733.73 | 2,030,146.16 |
| 210302 | Түлш, халаалт | 36,041,666.27 | 34,954,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,326,750.00 | 30,258,620.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,779,300.00 | 2,965,620.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,113,800.00 | 19,081,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,551,000.00 | 1,835,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,682,650.00 | 3,066,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,200,000.00 | 3,310,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 59,823,659.00 | 43,246,548.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 47,694,109.00 | 32,489,248.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,079,550.00 | 8,507,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,050,000.00 | 2,250,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,213,000.00 | 32,042,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,213,000.00 | 26,065,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 4,321,800.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,655,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,226,000.00 | 1,440,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,226,000.00 | 1,440,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,105,660.00 | 964,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,782,000.00 | 414,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 143,660.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 180,000.00 | 100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,220,135.00 | 6,614,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,220,135.00 | 6,614,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **200,000.00** | **1,560,453.73** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,560,453.84 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,570,667.90** | **(29,102,569.13)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 9,570,667.90 | (29,102,569.13) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 30,601,798.97 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 30,601,798.97 | 1,499,229.84 |

## **2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** (төгрөгөөр)

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 840,310,500.00 | 782,551,339.13 |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 840,310,500.00 | 782,551,339.13 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 840,310,500.00 | 782,551,339.13 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 615,520,685.84 | 557,851,524.97 |
| 210101 | Үндсэн цалин | 306,002,525.71 | 306,002,525.71 |
| 210102 | Нэмэгдэл | 219,997,563.89 | 162,328,403.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30,790,261.22 | 30,790,261.22 |
| 210104 | Урамшуулал | 58,730,335.02 | 58,730,335.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 73,239,600.00 | 73,239,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,042,800.00 | 52,042,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,299,600.00 | 5,299,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,649,500.00 | 2,649,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,649,500.00 | 2,649,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,598,200.00 | 10,598,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,984,646.16 | 36,984,646.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,030,146.16 | 2,030,146.16 |
| 210302 | Түлш, халаалт | 34,954,500.00 | 34,954,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,258,620.00 | 30,258,620.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,965,620.00 | 2,965,620.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,081,700.00 | 19,081,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,835,000.00 | 1,835,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,066,200.00 | 3,066,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,310,100.00 | 3,310,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,246,548.00 | 43,246,548.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 32,489,248.00 | 32,489,248.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,507,300.00 | 8,507,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,250,000.00 | 2,250,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 32,042,400.00 | 32,042,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 26,065,600.00 | 26,065,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,321,800.00 | 4,321,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,655,000.00 | 1,655,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,440,000.00 | 1,440,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,440,000.00 | 1,440,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 964,000.00 | 874,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 414,000.00 | 414,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 100,000.00 | 10,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,614,000.00 | 6,614,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,614,000.00 | 6,614,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 840,310,500.00 | 753,448,770.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 40,200,100.00 | 38,639,646.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 40,200,100.00 | 38,639,646.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 800,110,400.00 | 714,809,124.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 800,110,400.00 | 714,809,124.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **30,601,798.97** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **1,499,229.84** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 335,579.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 290,784.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

- *Насжилт өндөртэй авлага, өглөг ихтэй, тайлант онд шитгэлийн өглөг дутуу тусгасан 1.0 сая, тооцоо нийлсэн актгүй томилолтын өглөг 1.7 сая, эмийн эргэлтийн сангаас бөөн дүнгээр 13.2 сая төгрөгийн эм материалд хий орлого авч балансt өр тусгасан 17,749.3 мянган төгрөгийг бараа материалын тайланд тооцоо нийлж баталгаажуулан залруулсан*
- *Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллого хийсэн ч, 2013 онд ашиглалтад орсон мотоциклуудыг ашиглах боломжгүй, бодитоор оршин байхгүй байгааг ӨХЗ шийдвэрлээгүй, 37,119.0 мянган төгрөгийн шинээр бий болсон хөрөнгө орлого аваагүй байгааг үндсэн хөрөнгөд орлого авч залруулсан*
- *Санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлого дутуу илэрхийлсэн 53,718.2 мянга, мөнгөн хөрөнгийн тайланд зардал дутуу илэрхийлсэн 1,560.3 мянга, төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилт буруу илэрхийлсэн 180,717.4 мянган төгрөг, нийт 235,916.0 мянган төгрөг залруулсан*

Аудитаар нийт залруулагдаагүй мянган төгрөгийн 44,794.7 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 402,7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 17,525.7 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд 1 албан шаардлага, 26,866.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн. Нийт зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

***Илрүүлэлт:*** *ЭМГ-аас тендер нэгдсэн журмаар зарлаж тендерээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэг бүрийн үнийг тогтоож өгсөн бөгөөд тендерийн гэрээний үнийн дүнгээс өндөр үнээр шууд гэрээ байгуулан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан 0,4 сая төгрөгийн зөрчил илэрсэн.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.*

***Шийдвэрлэсэн нь:*** *Төлбөрийн акт тогтоосон*

### 5.2. Албан шаардлага

***Илрүүлэлт:***. *Эм зүйч байхгүйтэйгээс эмийн захиас, эмийн орлого 9.8 сая төгрөгөөр зөрүүтэй, бараа материалын эмийн үлдэгдэл 7.6 сая төгрөгөөр зөрүүтэй*

*[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

*тайлагнасан, эм эмнэлгийн хэрэгслийн тооллогоорх үлдэгдэл зөрүүтэй байгааг өмч хамгаалах зөвлөл хянаагүй, өмнөх оны зөвлөмж хэрэгжээгүй 17,525.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна*

***Шийдвэрлэсэн нь**: Хариуцлага тооцох албан шаардлага бичсэн*

**5.3. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**5.3.1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой**

***Илрүүлэлт:*** *Агуулахын бүртгэл хөтлөөгүй, хүнсний тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, агуулах эмх цэгцгүй, эд хөрөнгийн карт хөтлөөгүй, нярвын тайлан хангалтгүй, хөрөнгийг ангилан бүртгээгүй 16,590.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцээгүй байна.*

***Өгсөн зөвлөмж:*** *Агуулахын бүртгэл хөтөлж складын эмх цэгцийг сайжруулж дотоод хяналтыг сайжруулах*

**5.3.2 Эмийн зарцуулалттай холбоотой**

***Илрүүлэлт:*** *Эмийн үлдэгдлээс хяналт хэрэгжүүлэхэд 654 ширхэг 2.1 сая төгрөгийн насжилт өндөртэй эм, эмийн хэрэгсэл үлдэгдэлтэй байгаа зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**5.3.3 Шатахууны зарцуулалттай холбоотой**

***Илрүүлэлт:*** *Замын хуудсаар зарцуулсан шатахуун, бараа материалын зарцуулалтын шатахуун зөрүүтэй, шатахууны тооцоо хангалтгүй, анхан шатны баримаар нотлогдохгүй байгаа 8,168.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Ховд ЭМТ | Бараа материалын тайланд орлого аваагүй эмийн өр үүсгэсэн | 1 | 17,749.3 | 1 | 17,749.3 | | | 1 | 17,749,3 | | | | |
| | Санхүүгийн тайлангийн үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого буруу илэрхийлсэн | 1 | 235,916.0 | | | 1 | 235,916.0 | 1 | 235,916.0 | | | | |
| | Хөрөнгийн тооллого хийсэн ч, 2013 онд ашиглалтад орсон мотоциклуудыг ашиглах боломжгүй, бодитоор оршин байхгүй байгааг шийдвэрлээгүй, шинээр бий болсон хөрөнгө орлого аваагүй | 1 | 31,119.0 | 1 | 31,119.0 | | | 1 | 31,119.0 | | | | |
| **Нийт дүн** | | **3** | **284,784.3** | **2** | **48,868.3** | **1** | **235,916.0** | **3** | **284,784.3** | | | | |

### *6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс:** | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Дүн** | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | |
| | | | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |

Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ховд ЭМТ | Шууд худалдан авалтаар тендерээр нийлүүлж байгаа эм, эмийн хэрэгслээс илүү үнээр авсан нь эмийн өр үүсэх нөхцөл бүрдсэн | 1 | 402,7 | 1 | 402,7 | | | | |
| | Эм зүйч байхгүйтэйгээс эмийн захиас, эмийн орлого 9.8 сая төгрөгөөр зөрүүтэй, бараа материалын эмийн үлдэгдэл 7.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, эм эмнэлгийн хэрэгслийн тооллогоорх үлдэгдэл зөрүүтэй байгааг шийдвэрлээгүй, өмнөх оны зөвлөмж хэрэгжээгүй | 1 | 17,525.7 | | | 1 | 17,525.7 | | |
| | Замын хуудсаар зарцуулсан шатахуун, бараа материалын зарцуулалтын шатахуун зөрүүтэй, шатахууны тооцоо хангалтгүй, анхан шатны баримаар нотлогдохгүй байна | 1 | 8,168.6 | | | | | 1 | 8,168.6 |
| | Агуулахын бүртгэл хөтлөөгүй, хүнсний тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, агуулах эмх цэгцгүй, эд хөрөнгийн карт хөтлөөгүй, нярвын тайлан хангалтгүй, хөрөнгийг ангилан бүртгээгүй, | 1 | 16,590.0 | | | | | 1 | 16,590.0 |
| | Эмийн үлдэгдлээс хяналт хэрэгжүүлэхэд 654 ширхэг 2.1 сая төгрөгийн насжилт өндөртэй эм, эмийн хэрэгсэл үлдэгдэлтэй байна | 1 | 2,107.6 | | | | | 1 | 2,107.6 |
| | Дүн | 5 | 44,794.7 | 1 | 402,7 | 1 | 17,525.7 | 3 | 26,866.3 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

2025.02.24

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН

2025.02.24

БЭЛТГЭСЭН:

"ЦАХИМ АКТИВ АУДИТ ХХК" -НЫ АУДИТОР Д.БАЛЖИННЯМ 2025,02,24